

ТӨСӨЛ

“ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫГ ДЭМЖИХ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР /2017-2020 он/

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг цаг үеийн байдал, нийгмийн хэрэгцээнд нийцүүлэн төлөвлөж, гэр бүлийн эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, хэрэгжиж байгаа бөгөөд мөн Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон гэр бүлийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрүүд төсөл хэлбэрээр бэлтгэгдээд байна. Гэр бүлийн хөгжлийн өнөөгийн байдлын талаарх судалгаа, төрийн бус байгууллагууд болон иргэдээс үндэсний хэлэлцүүлгүүдэд ирүүлсэн санал зэргийг үндэслэн энэхүү хөтөлбөрийг боловсруулж байна.

Гэр бүлийн уламжлалт ёс заншлыг залуу хойч үеийнхэнд уламжлуулан өвлүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2010 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/526 тоот захирамжаар “Тэнгэрлэг гэр бүл”-ийг шалгаруулах журмыг батлан, 7 дахь жилдээ хэрэгжүүлж, 30 гэр бүлийг “Тэнгэрлэг гэр бүл”-ээр шалгаруулан алдаршуулж, тэдний ололт амжилт, үлгэр дууриаллыг иргэд, олон нийтэд сурталчлан ажиллаад байна.

Сүүлийн 20 жилийн хугацаанд Монгол улсын нийт өрхийн тоо 74.0 хувиар өсч, хот суурин газрын өрх 2 дахин нэмэгджээ. Хотын нийт өрхийн 54.4 хувийг шилжин суурьшсан өрх эзэлж байна.




Аймгийн хэмжээнд 2016 оны байдлаар Монгол улсын дүнгийн 1.6 хувь буюу 14128 өрх оршин сууж байна. Өрхийн тоо өнгөрсөн оноос 1.8 хувиар буюу 243 өрхөөр нэмэгдсэн байна.

Дундговь аймгийн нийт өрхийн өсөлтийг сүүлийн 5 жилээр авч үзвэл 2012 оноос хойш жилд 0,7-3,2 хувиар тогтмол өсч, нэг өрхөд ногдох ам бүлийн тоо 3,2 байна. Нийт өрхийн 76 хувь буюу 10752 нь эрэгтэй тэргүүлэгчтэй, 24 хувь буюу 3376 нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байна. Өрхийн хүн амын бүтэц хүн амын өсөлттэй уялдан өөрчлөгдсөөр байна.



Графикаас харахад 1-3 ам бүлтэй өрх нь нийт өрхийн 56,4 хувийг эзэлж байна. Иймд хүн амын өсөлтийг хангах бодлогыг хэрэгжүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, байгаль орчны тогтвортой байдлыг хангах, дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, боловсролыг тэргүүлэх салбарын хэмжээнд хүргэх талаар гаргасан зорилтуудыг ханган биелүүлж, аймгийн нийт хүн амын тоог өсгөх шаардлагатай байгаа бөгөөд гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих төсөл хөтөлбөрийг бий болгох нь нийгэмд хүлээгдээд буй хэрэгцээ байна гэж үзэж байна.

Гэрлэлт нь гэр бүл бүрдэх үндэс бөгөөд гэр бүл бол хүний хөгжлийн анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж юм. Гэвч анхны гэрлэлтийн дундаж нас хойшилж, гэрлэлтээ батлуулахгүйгээр хамтран амьдрах хэв шинж хүн амын дунд нэмэгдэж байна. Гэр бүлтэй нийт хүн амын 12,8 хувийг хамтран амьдрагч буюу хууль ёсоор гэрлэлтээ батлуулаагүй хүмүүс эзэлж байгаа бөгөөд ихэвчлэн 20-35 насныхан зонхилж байна. Анхны гэрлэлтийн нас хойшилж, эрэгтэйчүүд 26, эмэгтэйчүүд 24 насандаа тус тус гэрлэх болжээ.



2016 онд гэрлэлтээ батлуулсан гэр бүлийн тоо нь 2014 оны мөн үеийнхтэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байгаа нь гэрлэлтээ батлуулахгүй хамтран амьдрагч нар олноор бий болж буйн илэрхийлэл юм.

Дундговь аймгийн хувьд гэр бүлээ батлуулсан хүн амын эзлэх хувь 2007-2009 онд хамгийн их буюу 64,9 хувийг эзэлж байгаа бол 2014-2016 онд хамгийн бага буюу 17,9 хувийг эзэлсэн байна. 2007-2008 онд төр засгаас залуу гэр бүлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнд залуучууд гэр бүл болох нь нэмэгдсэнтэй холбон тайлбарлаж болох юм.

Аймгийн хэмжээнд 2016 оны хувьд 169 гэрлэлт бүртгэгдсэн нь өмнөх оноос 13-аар буурсан байна.Цуцлалт 32 бүртгэгдсэн нь өмнөх оноос 1-р буурсан. Цуцлуулсан гэр бүлийн 23 нь буюу 71,8 хувь нь 7-дээш жил хамт амьдарсан гэр бүл байгаа бол 28,2 хувь нь 1-6 жил хамт амьдарсан гэр бүл байна

Жилийн эцсийн байдлаар өрх толгойлсон гэр бүлгүй эрэгтэй, эмэгтэй хүний тоо 2436 байгаа нь өмнөх оноос нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо 2016 онд 1846 болж, 2015 оныхоос 5.5 хувиар нэмэгдсэн байна.

Өрх гэрийн орлого ганц хүний цалингаар хэмжигдэж, үр хүүхдийнхээ сургуулийн өмнөх болон сургуулийн боловсрол, хүмүүжлийн асуудалд санаа тавьж чадахгүй байгаа нь тогтвортой ажиллах, амьдрах нөхцөлөө бүрдүүлэх, гэр бүлийн асуудлаа шийдвэрлэхэд хүндрэлтэй, тулгамдсан асуудлуудын нэг болоод байгаа юм.

Дээрх бүх жишээ баримтад тулгуурлан үзэхэд гэр бүлд чиглэсэн хөгжил, хамгааллын хөтөлбөрийг орон нутгийн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлснээр хүний амьдралын анхдагч орчин болох гэр бүлийн гишүүдийн хандлага өөрчлөгдөж, тогтвортой, эерэг харилцаатай гэр бүл төлөвшиж, хүүхдэд ээлтэй орчин бүрдэнэ гэж үзэж байна.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН УЯЛДАА, ХОЛБОО

Энэхүү хөтөлбөр нь “Гэр бүлийн тухай”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай”, “Хүүхдийн эрхийн тухай”, “Хүүхэд хамгааллын тухай”, “Хүүхэд харах үйлчилгээний тухай” хуулиуд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас дэвшүүлсэн салбарын зорилго, зорилт, Дундговь аймгийн Засаг даргын 2016-2020

оны үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөө, холбогдох үндэсний хөтөлбөрүүдтэй уялдуулан хэрэгжүүлнэ.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, гэр бүлийн хөгжил, боловсрол, тогтвортой байдлыг дэмжих, нийгмийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх замаар гэр бүлийн гишүүдийн тэгш оролцоог хангах нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ

4.1. Гэр бүлийн харилцаанд жендерийн тэгш байдал, гэр бүлийн гишүүдийн жигд оролцоог хангахыг дэмжинэ.

4.2. Гэр бүлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, гэр бүлийг хөгжүүлэхэд чиглэгдсэн үйлчилгээг хөхүүлэн дэмжинэ.

4.3. Гэр бүл дэх хүний эрхийг дээдэлж, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, гэр бүлийн нийгмийн үнэ цэнийг бий болгоход чиглэсэн нийгмийн орчинг бий болгохыг дэмжинэ.

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ХҮРЭХ ҮР ДҮН

Дундговь аймгийн 15 сумын 14128 өрхийн 45515 хүн амын 50%-ийг хамруулна.

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ХҮРЭХ ҮР ДҮН

Зорилт 1. Гэр бүлийн эрхзүйн орчны хэрэгжилтийг эрчимжүүлж, нийгмийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх замаар тогтвортой байдлыг хангах, гэр бүлд ээлтэй нийгмийн орчинг бүрдүүлэх

Чиглэсэн үйл ажиллагаа

1. Гэр бүлийн харилцааг зохицуулж буй хууль, тогтоомжийн хэрэгжилт, сургалт нөлөөллийн ажлуудыг тогтмол зохион байгуулах
2. Гэр бүлд зөвлөгөө өгөх төвийг тохижуулж үйл ажиллагааг тогтмолжуулан, сэтгэл зүйч ажиллуулна
3. Хохирогч болон хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлийг өөрчлөх, архи, тамхи, мансуурах төрлийн хэрэглээтэй иргэдийг хорт зуршлаас гаргах нөлөөллийн сургалт, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх
4. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хохирогчдыг хамгаалах “Түр хамгаалах байр”-ны үйл ажиллагааг тогтмолжуулах

Хүрэх үр дүн:

1. Гэр бүл дэх хүний эрхийг хангах нийгмийн оюун санааны орчинд эерэг өөрчлөлт бий болно.
2. Гэр бүлийн сургалт зөвлөгөө өргөжин хөгжиж, гэр бүлийн хүрээний сөрөг асуудлууд бууран, гэр бүлийн тогтвортой байдал хангагдана.
3. Гэр бүлийн хүчирхийлэл буурна.
4. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод учирч болох аливаа асуудлыг хугацаа алдалгүй шийдвэрлэх боломж бүрдэнэ.

Зорилт 2. Эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, гэр бүл дэх хүүхдийн хөгжил хамгааллыг бэхжүүлэх

Чиглэсэн үйл ажиллагаа

1. Аймгийн “Тэнгэрлэг гэр бүл”-ийг шалгаруулах, гэр бүлийн зөвлөгөөн зохион байгуулах
2. Хүн амын тодорхой бүлгүүдийг хамарсан чуулган зохион байгуулах /эцэг эхийн, эмэгтэйчүүдийн, гэр бүлийн гэх мэт/
3. Гэр бүлийн гишүүдийг оролцуулсан уралдаан тэмцээн, нөлөөллийн ажлуудыг тогтмол зохион байгуулах

Хүрэх үр дүн:

1. Гэр бүлийн гишүүдийн амьдралд хандах хандлагад эерэгээр нөлөөлөх нийгэм, сэтгэлзүйн орчин бий болж хариуцлага дээшилнэ.
2. Гэр бүл нь хүний амар тайван аж төрж хөгжих анхдагч орчин байх үүргээ гүйцэтгэж, үнэ цэнэ нь нэмэгдэнэ.
3. Гэр бүлийн эерэг харилцаа, хүүхдэд ээлтэй гэр бүлийн орчин бүрдэхэд аж ахуйн нэгж байгууллага, хамт олны оролцоо нэмэгдэнэ.
4. Эцэг эх, хүүхэд, гэр бүлийн гишүүдийн хоорондын дотоод уур амьсгал сайжирч, бие биедээ хандах хандлагад эерэг өөрчлөлт бий болно.

Зорилт 3. Гэр бүлийн боловсрол олгох замаар гэр бүлийн сайн сайхан байдлыг хангах

Чиглэсэн үйл ажиллагаа

1. Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёл урлагийн газартай хамтран, Өсвөр үе, залуучуудад гэр бүл төлөвлөлт, амьдрах ухаан, нөхөн үржихүйн боловсрол олгох сургалт, сурталчилгаа зохион байгуулах
2. Гэр бүлүүдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах замаар гэр бүлийн боловсрол олгох
3. Гэрлэлтээ батлуулахаар төлөвлөсөн хосуудыг гэр бүлийн боловсрол олгох сургалтад хамруулж, сургалтад хамрагдсан гэр бүлүүдийн гэр бүлийн баталгааг баталж хэвших

Хүрэх үр дүн:

1. Өсвөр үеийнхэн, залуучууд гэр бүлийн боловсролтой болж, гэр бүл төлөвлөлт бий болсноор хүсээгүй жирэмслэлт, гэр бүлийн тогтворгүй байдал багасна.
2. Гэр бүлийн боловсрол олгох үйл ажиллагаа, сургалт эрчимжсэнээр иргэдийн мэдлэг ойлголт дээшилнэ.
3. Гэр бүлүүд иргэний үүргээ биелүүлж, гэр бүлийн хүрээнд үүсэх сөрөг асуудлууд буурна.

Зорилт 4. Гэр бүлд зориулсан зөвлөгөө, сургалтын ажлыг өргөжүүлж, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах

Чиглэсэн үйл ажиллагаа

1. Амьдарлын зөв хэвшил, амьдрах арга ухааныг сурталчилсан “Гэр бүлийн цаг” телевизийн цуврал нэвтрүүлэг тогтмол бэлтгэн олон нийтэд хүргэх
2. Гэр бүлийн гишүүдийн бие биедээ тавих анхаарал халамж, хүүхдэд зарцуулах цагийг бий болгох “Гэр бүлийн өдөр” арга хэмжээг зохион байгуулах
3. Гэр бүлд зөвлөн туслах сургалт зохион байгуулах, мэдээлэл сурталчилгаа хийж буй төрийн бус байгууллагуудын аливаа үр дүнтэй мэргэжлийн үйл ажиллагааг дэмжих, түгээх

Хүрэх үр дүн:

1. Гэр бүлийн гишүүд өөрийн санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, өөрийгөө хүндэтгэх, амьдралд тулгарсан саад бэрхшээлийг эрхзүйн орчин хийгээд, мэргэжлийн үйлчилгээний тусламжтай шийдвэрлэх боломж бүрдэнэ.
2. Гэр бүлийн гишүүдийн бие биенээ ойлгох, хамдтаа цагийг хөгжилтэй өнгөрүүлэх боломжийг бүрдүүлнэ.
3. Төр, төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирна.

Зорилт 5. Залуу гэр бүлийг дэмжин, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах

Чиглэсэн үйл ажиллагаа

1. Залуу эцэг, эхчүүдэд зориулан хүүхдээ эрүүл өсгөн бойжуулах, хөгжлийг нь дэмжих хийгээд анхны жилүүдийн хямралыг даван туулах, ойлголцох, зөрчлийг шийдвэрлэхэд туслах сургалт зөвлөгөөнд хамруулах
2. Залуу гэр бүлүүдэд “Гэр бүлийн үнэ цэнэ”, гэр бүлдээ хүлээх үүрэг хариуцлагын талаар сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах
3. 4-өөс дээш хүүхэдтэй залуу гэр бүлийн ахуйн нөхцөл, орон сууцны хангамжид анхаарах асуудлыг ажил олгогчидтой хамтран шийдвэрлэх боломжийг нэмэгдүүлэх,
4. Залуучуудын ажлын байрыг нэмэгдүүлж, гэр бүлийн санхүүгийн чадавхийг дээшлүүлэх, эдийн засгийн чадавхигүй залуу гэр бүлд дэмжлэг үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх,

Хүрэх үр дүн

1. Залуу гэр бүлийн амьдралыг бэхжүүлэх бодлого хэрэгжүүлснээр гэр бүлийн сөрөг асуудлууд, салалт буурна.
2. Залуу гэр бүлүүдийн гэр бүлдээ хүлээх үүрэг хариуцлага нэмэгдэнэ.
3. Ажил олгогчдын хувьд ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд нөлөөлөхөөс гадна залуучууд урт удаан тогтвортой ажилтай байх нөхцөл бүрдэнэ.
4. Гэр бүл, хүүхдийн хувьд эрсдлээс хамгаалагдах боломж нэмэгдэнэ.

Зорилт 6. Угийн бичиг хөтлөх үйл ажиллагааг эрчимжүүлж, цус ойртолтоос сэргийлэн монгол хүний удмын санг хамгаалах

Чиглэсэн үйл ажиллагаа

1. Цус ойртолтоос сэргийлж, ураг удмаа мэдэх, ураг төрлийн үнэн зөв холбоог илтгэсэн овог удмын нэртэй байх явдлыг иргэн бүрт ойлгуулж Монгол хүний генийн санг хамгаалах хөдөлгөөн өрнүүлэх,
2. Угийн бичиг хөтлөх зөвлөмж, гарын авлага, хэрэглэгдэхүүнүүдийг бэлтгэх, ашиглах материалуудыг хэвлэн гаргах,
3. Удмын нэрийг гэр бүлийн угийн бичигт тэмдэглэн хэрэглэх болон түүний ач холбогдлын талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийг ашиглан мэдээлэл сурталчилгаа бэлтгэн явуулах,

Хүрэх үр дүн

1. Монгол өрх бүр ургийн бичиг хөтөлж генийн сангийн цэвэр байдлаа хадгалах боломж бүрдэж үндэсний аюулгүй байдал хангагдах нэг нөхцөл бүрдэнэ.
2. Ургийн бичиг хөтлөх тодорхой заавар мэдээлэл өргөн хүрээнд тархана.
3. Монгол улсын иргэний үнэмлэх дээр байдаг ураг төрлийн хамаарлыг заах үүргээ биелүүлдэггүй худал овгуудыг цаашид үнэн зөв удмын нэрээр солих үндэс суурь тавигдана

Зорилт 7. Зорилтот гэр бүлийг дэмжих замаар тэдний нийгмийн баталгааг хангах

Чиглэсэн үйл ажиллагаа

1. Өрх толгойлсон хүүхэдтэй эцэг, эхийг ажлын байраар хангасан, зорилтот гэр бүлийн гишүүдийн өрхийн үйлдвэрлэлийг дэмжин, ажил эрхлэх боломжийг бүрдүүлсэн байгууллага, аж ахуй нэгжийг урамшуулах
2. Шинээр гэр бүл болсон цөөн малтай өрхүүдийг малжуулах төсөл хөтөлбөрт хамруулах, дэмжлэг үзүүлэх
3. Шинээр томилогдон ирж буй хууль, цэргийн байгууллага болон төрийн албан хаагчдын ар гэрийн хүнийг ажлын байранд зуучлах замаар гэр бүлийн тогтвортой байдлыг бий болгох

Хүрэх үр дүн

1. Зорилтот гэр бүлийн санхүүгийн асуудлыг шийдвэрлэн, тэдний амьдралд хандах хандлагад эерэг өөрчлөлтийг бий болгоно.
2. Гэр бүлүүдийн дунд үүсдэг аливаа үл ойлголцол арилж, гэр бүлийн халуун дотно харилцааг бий болгоно.

НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХУГАЦАА, САНХҮҮЖИЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САЛБАР ДУНДЫН ОРОЛЦОО

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа

- Хөтөлбөрийг 2018-2020 оныг дуустал хэрэгжүүлнэ.

8.2. Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр

- 7.2.1. Засаг даргын нөөц хөрөнгө
- 7.2.2. Орон нутгийн хөгжлийн сан
- 7.2.3. Олон улсын болон төрийн бус байгууллагын тусламж, дэмжлэг
- 7.2.4. Улсын төсөв

8.3. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

8.3.1. Хөтөлбөрийн удирдах дээд байгууллага нь Засаг даргын тамгын газар байна. Засаг даргын тамгын газар нь хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн нийгэм, эдийн засгийн бодлого, хүний хөгжлийн асуудлаарх бусад хөтөлбөртэй уялдуулан зохицуулах үйл ажиллагаа явуулна.

8.3.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг ГБХЗХГазар хариуцна.

8.3.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулагдана.

ЕС. ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ

9.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл явцад салбаруудын оролцоог хангаж, хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл явцыг хагас, бүтэн жилээр салбар дундын хэлэлцүүлгээр дамжуулан хянах, мэдээлэх боломжийг бүрдүүлэх

9.2 Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг аймгийн Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын хяналт шинжилгээ үнэлгээний алба зохицуулна.

АРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлт	Суурь түвшин /2017 он/	Хүрэх түвшин		
			2018	2019	2020
1	Гэр бүлийн боловсрол олгох бодлого, стратегитэй уялдуулан зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлгийн тоо	30	40	50	60
2	Гэр бүл, хүүхдэд ээлтэй бодлогыг хэрэгжүүлсэн байгууллагын тоо	11	23	23	23
3	Албан байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд “Гэр бүл”-ийн зөвлөл байгуулж ажилтнуудынхаа гэр бүлийн хөгжил, хамгааллыг дэмжиж бүтээлчээр туслах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байгууллагын тоо	11	23	23	23
4	Гэр бүлийн үнэ цэнэ, сайн сайхан байдлыг сурталчлах, гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр хийгдсэн телевизийн нэвтрүүлгийн тоо	0	2	4	6
5	Гэр бүлийн хөгжил хамгааллын чиглэлээр сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, чуулган, уулзалтанд хамрагдсан хүмүүсийн тоо	13024	15171	22757	25000
6	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоо	10/25	10/37	10/40	10/30
7	Гэр бүлийн хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн хүний тоо, зөвлөгөө авсан хүмүүсийн тоо	3040	4000	5000	6000
8	Угийн бичиг хөтлөх сургалтад хамрагдаж, мэдээлэл авсан хүний тоо	303	800	1300	1800
9	Гэр бүлийн гишүүдийг оролцуулсан уралдаан тэмцээн наадам нөлөөллийн ажлын тоо	50	70	90	110
10	Хамгаалах байраар үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн тоо	0	30	40	30

---oOo---